



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ 2021



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ - 2021

УЛААНБААТАР ХОТ
2021



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Эрхэлсэн: Д.Нарантуяа

ЭЭХХЗГ-ын дарга

Хянасан: Д.Уранзаяа

ЭЭХХЗГ-ын дэд дарга

Эмхэтгэсэн:

Б.Тэмүүлэн

ЭЭХХЗГ-ын ЗУГ-ын мэргэжилтэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

Н.Мөнхзаяа

ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын мэргэжилтэн

Мэдээлэл цуглуулсан:

Г.Номин

ЭЭХХЗГ-ын ЧХГ-ын улсын ахлах байцаагч

Р.Энхсүрэн

ЭЭХХЗГ-ын ЭТТГ-ын ахлах мэргэжилтэн

Ш.Ариунзаяа

ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын мэргэжилтэн

Г.Мядагмаа

ЭЭХХЗГ-ын ЭХГ-ын мэргэжилтэн

А.Номиндарь

ЭЭХХЗГ-ын ЛЗЗГ-ын мэргэжилтэн

Э.Гэрэлт-Эрдэнэ

ЭЭХХЗГ-ын ЭБХ-ийн мэргэжилтэн

Б.Хувьтавилан

ЭЭХХЗГ-ын ЭШЛ-ийн ахлах мэргэжилтэн

Э.Одбаяр

ЭЭХХЗГ-ын ЭҮХ-ийн ахлах мэргэжилтэн

Э.Баасандорж

ЭЭХХЗГ-ын ЭҮХ-ийн мэргэжилтэн

ЭМ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН, ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР


Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот,

Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,

УВН төв, 8 давхар

Утас: 51-260182

Э-шуудан: info@mmra.gov.mn, www.mmra.gov.mn



ӨМНӨХ ҮГ



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг -Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас “Эм зүйн салбарын үзүүлэлт-2021” эмхэтгэлийг та бүхэндээ хүргэж байгаадаа таатай байна. Эм зүйн салбарын үндсэн үзүүлэлтийг эмхэтгэн, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчид ба бусад хэрэглэгчдийн хүртээл болгох нь эрүүл мэндийн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Энэ удаагийн эмхэтгэлд эм зүйн салбарын хүний нөөц, эм хангамжийн байгууллага, эдийн засгийн тоон мэдээлэл болон эмийн бүртгэл, чанар аюулгүй байдал, зохистой хэрэглээтэй холбоотой статистик үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулан тусгаж, эрхэм хэрэглэгч Та бүхэнд толилуулж байна.

Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх зорилтын нэн тэргүүнд эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал тавигдаж байна.


Зорилтыг хангах олон арга хэмжээг цаашид хэрэгжүүлж, жил бүрийн “Эм зүйн салбарын үндсэн үзүүлэлт” эмхэтгэлд тусган Та бүхний хүртээл болгох болно.

Д.НАРАНТУЯА

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА, АНАГААХ УХААНЫ ДОКТОР


ГАРЧИГ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	7
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	8
1. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	10
1.1 МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ	10
1.2 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ	12
1.2.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН	12
1.2.2. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН	12
2. ЭМ ЗҮЙН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ	14
2.1. ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ	14
2.2. ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ	19
2.2.1. ҮЙЛДВЭРЛЭЛ	19
2.2.2. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА	21
2.2.3. ЭМИЙН САН	22
2.3. ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ	24
2.4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	26
2.4.1. ЭМИЙН САНХҮҮЖИЛТ	26
2.4.2. ЭМИЙН ИМПОРТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА	28
2.4.2.1. ЭМИЙН ИМПОРТ	28
2.4.2.2. ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ	30
2.4.3. ЭМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, ТҮГЭЭЛТ	32
2.5. ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТ	33
2.5.1. ЭМИЙН БҮРТГЭЛ	33
2.5.2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ	37
2.5.3. ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ	39
2.5.4. ЭМИЙН СОНГОЛТ	39
2.5.5. ЭМИЙГ ЗАХ ЗЭЭЛД ТАНИУЛАХ ЗАР СУРТАЧИЛГАА	40
2.5.6. МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМ	42
2.6. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГА	46
ХАВСРАЛТ 1. ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН IХ ЖАГСААЛТ	50
ХАВСРАЛТ 2. ХҮҮХДИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН II ЖАГСААЛТ	74

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, сонгосон онуудаар	10
Зураг 2. Хүн амын дундаж наслалт, сонгосон онуудаар	11
Зураг 3. Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр (2021)	11
Зураг 4. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 10,000 хүн амд 2011-2021	12
Зураг 5. Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10 000 хүн амд	12
Зураг 6. Нийт үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагын тоо (2016-2021)	19
Зураг 7. Үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл (2021)	19
Зураг 8. Нийт үйлдвэрийн ангилалын эзлэх хувь (2021)	20
Зураг 9. Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийн эзлэх хувь	21
Зураг 10. Ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны чиглэл (2021)	21
Зураг 11. Үйл ажиллагаа явуулсан эмийн сангийн тоо (2019-2021)	23
Зураг 12. Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн тоо (2015-2021)	26
Зураг 13. Эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо (2015-2021)	26
Зураг 14. Эрүүл мэндийн төсөв, /тэрбум төгрөг/ (2015-2021)	27
Зураг 15. ЭМДС-аас олгосон эмийн үнийн хөнгөлөлт /тэрбум төгрөг/	27
Зураг 16. ЭМД-аас хамгийн их хөнгөлттэй олгосон 10 нэрийн эм, ширхэгээр	28
Зураг 17. Эмийн импорт, борлуулалт, /тэрбум төгрөг/ (2015-2021)	28
Зураг 18. Эмнэлгийн хэрэгслийн импорт, борлуулалт /тэрбум төгрөг/	29
Зураг 19. Урвалж, стандарт бодисын импорт, борлуулалт, /тэрбум төгрөг/	29
Зураг 20. Оношлуурын импорт, борлуулалт /тэрбум төгрөг/ (2015-2021)	30
Зураг 21. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, /тэрбум төгрөг/	31
Зураг 22. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувь (2021)	31
Зураг 23. Эм, эмнэлгийн хэрэгслийн төсөвт өртөг ба худалдан авах ажиллагааны гэрээний дүн, /тэрбум төгрөг/ (2015-2021)	32
Зураг 24. Худалдан авсан нэр төрлийн эзлэх хувь (2021)	32
Зураг 25. Монгол улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эм (1994-2021)	33
Зураг 26. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эдийн тоо (2016-2021)	33
Зураг 27. Бүртгэлтэй эмийн олгох нөхцөл /хувиар/ (2021)	34
Зураг 28. Монгол улсын эмийн бүртгэлд хамгийн их бүртгэгдсэн эхний 10 улс, хувиар (2021)	34
Зураг 29. Эмийн бүртгэлд үндэсний үйлдвэрийн эмийн эзлэх хувь (2016-2021)	35
Зураг 30. АТС ангилал эзлэх хувиар (2021)	35

Зураг 31. Монгол улсад бүртгэгдсэн эм, БИБ, оношлуур (2017-2021)	36
Зураг 32. Монгол улсад оношлуурын бүртгэл (2016-2021)	36
Зураг 33. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын тоо	37
Зураг 34. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын хувь	37
Зураг 35. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй бүтээгдэхүүний ангилал	38
Зураг 36. Эмийн гаж нөлөөний мэдээлэл (2017-2022)	39
Зураг 37. Зөвшөөрөл олгосон зар сурталчилгааны тоо (2016-2021)	41
Зураг 38. Эм, БИБ-д олгосон зар сурталчилгааны тоо (2016-2021)	41
Зураг 39. Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн эмийн хэрэглэх заавар (2020-2021)	42
Зураг 40. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жорын зарцуулалт (2021)	42
Зураг 41. МУ-д бүртгэлтэй дан болон нийлмэл найрлагатай мансууруулах, сэтгэц нөлөөт эм (2021)	43
Зураг 42. Импортолсон болон дотоодод үйлдвэрлэсэн мансууруулах, сэтгэцэд нөлөөт эм (2021)	43
Зураг 43. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн олгох нөхцөл (2021)	44
Зураг 44. МУ-д бүртгэлтэй мансууруулах эмийн эзлэх хувь, үйлдвэрлэгч хувиар (2021)	44
Зураг 45. МУ-д бүртгэлтэй сэтгэцэд нөлөөт эмийн эзлэх хувь	45
Зураг 46. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо (2017-2021)	46
Зураг 47. Шалгалт тохируулгад хамрагдсан тоног төхөөрөмжийн тоо	47



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Эм хангамжийн байгууллагын тоо (2017-2021)	19
Хүснэгт 2. Шинээр авсан үйл ажиллагааны чиглэл	20
Хүснэгт 3. Эмийн сан, байршлаар (2017-2021)	22
Хүснэгт 4. Үйл ажиллагаа явуулсан эмийн сан, байршлаар (2021)	23
Хүснэгт 5. 2021 онд орон нутагт эрүүл мэндийн салбарт ажилласан эм зүйч, эм найруулагчийн тоо, байршлаар	24
Хүснэгт 6. Эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо	25
Хүснэгт 7. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй бүтээгдэхүүний тоо	38
Хүснэгт 8. Монгол улсын Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт /түгээх салбар, эмнэлэг, мэргэжлийн төв, эмийн сангаар/	40
Хүснэгт 9. Шалгалт тохируулгад хамрагдсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоо (2017-2021)	47

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АӨСҮТ	Арьсны өвчин судлалын үндэсний төв
АУК	Анагаах ухааны коллеж
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БОЭТ	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв
БНЭУ	Бүгд Найрамдах Энэтхэг улс
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ЭЗШУИС	Эм зүйн шинжлэх ухааны их сургууль
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
АТС	Anatomical Therapeutic Chemical
MNS	Mongolian National Standard
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани




ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1. ХҮН АМ ЗҮЙН БОЛОН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ



1.1. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

Монгол улсын хүн ам 2021 онд 3'409'939 болж, сүүлийн 100 жилийн хугацаанд 2.76 саяар нэмэгдсэн байна. 2020 оноос 52.6 мянган хүнээр өслөө. Нийт хүн амын 69.4% нь хот суурин газар, үлдсэн 30.6% хөдөө амьдарч байна. Хүн амын 1'674'057 нь эрэгтэйчүүд, 1'735'882 нь эмэгтэйчүүд байна. 2021 оны байдлаар нийт хүн амын 32.1% 15 хүртэлх насны хүүхэд, 63.4%-ийг 15-64 насны хүн ам, 4.4%-ийг 65-аас дээш насныхан эзэлж байна. /Зураг-1/



Зураг 1: Хүн амын тоо, жилийн дундаж өсөлтийн хувь, сонгосон онуудаар
 Эх үүсвэр: Статистикийн мэдээллийн сан- www.1212.mn


Хүн амын дундаж наслалт 2021 онд улсын хэмжээнд 71.01 болж өмнөх оноос 0.3 жилээр өссөн бөгөөд эмэгтэйчүүдийн дундаж наслалт 76.47, эрэгтэйчүүдийнх 67.05 жил болсон байна. Дундаж наслалт нь хүйс, одоогийн нас, амьдралын хэв маяг зэргээс шалтгаалан ялгаатай байдаг. Монгол хүний дундаж наслалт 1992 онд 65.5 байсан бол 2021 онд 71.01 болж сүүлийн 30 орчим жилийн хугацаанд 5.5 жилээр нэмэгдсэн байна. /Зураг-2/



МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ

Зураг 2. Хүн амын дундаж наслалт, сонгосон онуудаар (1992-2021)

Хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалтыг аймгуудаар авч үзвэл Дундговь аймаг улсын дунджаас харьцангуй өндөр буюу 2.5 жилээр их, Хөвсгөл аймаг харьцангуй бага буюу 3.9 жилээр бага байна. /Зураг-3/




Зураг 3. Хүн амын дундаж наслалт, аймаг, нийслэлээр (2021)

Дундаж наслалт аймаг, бүсүүдээр ялгаатай байгаа ба Хангайн бүсийн хүн амын дундаж наслалт хамгийн бага буюу 71.65, Зүүн бүсийн хүн амын дундаж наслалт хамгийн өндөр буюу 72.37 байна.

1.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТ

1.2.1. ХҮН АМЫН ӨВЧЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

2021 оны байдлаар 10,000 хүн амд, хоол боловсруулах тогтолцооны өвчин 1354.2, зүрх-судасны тогтолцооны өвчин 936.5, амьсгалын тогтолцооны өвчин 788.4, шээс бэлгийн тогтолцооны өвчин 682.3, гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчин 475.8 ногдож байгаа бөгөөд 2020 онтой харьцуулахад өвчлөлийн тэргүүлэх шалтгаанууд 12-685-аар буурсан үзүүлэлтэй байна. /Зураг-4/




Зураг 4. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан, 10 000 хүн амд (2011-2021)

1.2.2. ХҮН АМЫН НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ ШАЛТГААН

Монгол улсын хүн амын нас баралтын шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин, хавдар, зүрх-судасны тогтолцооны өвчин 1990 онд тэргүүлж байсан бол 1995 оноос одоог хүртэл зүрх-судасны тогтолцооны өвчин, хавдар, гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралт тэргүүлсээр байна. /Зураг-5/

2021 оны байдлаар хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10 000 хүн амд:

- Зүрх-судасны тогтолцооны өвчин 18.9
- Хавдар 12.9
- Гэмтэл хордлого, нас баралтын гадны шалтгаант 9.2
- Хоол боловсруулах тогтолцооны өвчин 3.5
- Амьсгалын тогтолцооны өвчин 2.9



Зураг 5. Нас баралтын тэргүүлэг 5 шалтгаан, 10 000 хүн амд




ЭМ ЗҮИН САЛБАРЫН ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

2.1. ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

2021 оны байдлаар Монгол улсын эм зүйн салбарт дараах эрх зүйн баримт бичгийг мөрдөн ажиллав.

ХУУЛЬ (ЦАГААН ТОЛГОЙН ҮСГИЙН ДАРААЛЛААР)

- Авлигын эсрэг
- Аж, ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай
- Аудитын тухай
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай
- Архидан согтуурахтай тэмцэх тухай
- Байгууллагын нууцын тухай
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай
- Гамшгаас хамгаалах тухай
- Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай
- Гаалийн тухай
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Дархлаажуулалтын тухай
- Донорын тухай
- Зар сурталчилгааны тухай
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай
- Захиргааны ерөнхий хууль
- Зөрчлийн тухай
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай
- Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай
- Монгол улсын Засгийн газрын тухай
- Монгол Улсын Үндсэн хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай
- Төрийн албаны тухай
- Төрийн болон албаны нууцын тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
- Төрийн хяналт, шалгалтын тухай
- Төсвийн тухай
- Үндэсний аюулгүй байдлын тухай
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
- Хөдөлмөрийн тухай
- Хувь хүний нууцын тухай
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай
- Эрүүл мэндийн тухай хууль



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц
- Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц

УИХ-ЫН ТОГТООЛ

- “АЛСЫН ХАРАА-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай
- Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


- Агентлаг байгуулах тухай – Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 222 дугаар тогтоол)
- Дүрэм батлах тухай – Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм (2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоол)
- Журам батлах тухай – Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам (2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоол)
- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай (Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоол)
- Журам шинэчлэн батлах тухай – Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол)
- Журам шинэчлэн батлах тухай – Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам (2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 206 дугаар тогтоол)
- Журам батлах тухай – “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулах журам (2008 оны 08 дугаар сарын 01-ны өдөр 190 дугаар тогтоол)
- Журам шинэчлэн батлах тухай – Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам (2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 216 дугаар тогтоол)
- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай (Шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын жагсаалт) (2003 оны 196 дугаар тогтоол)
- Нийтлэг журам батлах тухай – ААНБ-ын дотоод хяналт шалгалт (2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоол)
- Улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журам (2002 оны 219 дүгээр тогтоол)
- Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам (2020 оны 12 дугаар сарын 16-ны 218 дүгээр тогтоол)
- Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай (2011 оны 73 дугаар тогтоол)

САЙДЫН ТУШААЛ

- Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах (Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 117 дугаар тушаал)
- Шалгалт баталгаажуулалтад хамруулах хэмжих, хэрэгслийн жагсаалт (Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 125 дугаар тушаал)
- Амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг зохицуулах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаал)
- Бүртгэлийн болон GMP-ын шинжээч ажиллуулах журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 225 дугаар тушаал)
- Гадаад, дотоодын эм үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газрын ажиллах журам (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 284 дугаар тушаал)
- Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэн мэдээлэх, тандах журамд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/278 дугаар тушаал)
- Зайлшгүй шаардлагатай эмийн 9 дэх, Хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн 2 дах жагсаалт шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/625 дугаар тушаал)
- Монгол улсын хүн амын эмчилгээнд хэрэглэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/184 дүгээр тушаал)
- Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэх, ханган нийлүүлэх журам батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 68 дугаар тушаал)
- Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай
- Монгол улсын үндэсний фармакопейд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/219 дугаар тушаал)
- Өнчин эмийн жагсаалт батлах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 271 дүгээр тушаал)

ӨНЧИН ЭМИЙН ЖАГСААЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

- Өнчин эмийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай
- Тусламж, хандиваар эм, эмнэлгийн хэрэгслийг нийлүүлэх, хүлээн авах, хэрэглэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/232 дугаар тушаал)
- Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам батлах тухай (Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 129/100 дугаар тушаал)
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг 2020-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/103 дугаар тушаал)
- Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай (Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн эрүүл мэндийн салбарт хэрэгжих үйл ажиллагааны төлөвлөгөө) (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/289 дугаар тушаал)
- Фармакопей боловсруулах, батлах, дугаар өгөх, фармакопейн хорооны бүрэлдэхүүн, ажиллах журам шинэчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын



2014 оны 132 дугаар тушаал)

- Хлорт фторт нүүрстөрөгч агуулсан ингаляци хэлбэрийн эмийн бүртгэлийг зогсоох тухай (Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2009 оны 217/259 дүгээр тушаал)
- Хүний эмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/127 дугаар тушаал)
- Цахимаар эмийн жор бичих, олгох заавар батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/495 дугаар тушаал)
- Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаал)
- Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн, мэдээлэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2013 оны 415 дугаар тушаал)
- Эмийн зах зээлийн дараах тандалт судалгаа хийх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2014 оны 33 дугаар тушаал)
- Эмийн зах зээлийн дараах тандалт судалгаа хийх журамд өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 88 дугаар тушаал)
- “Эмийн гаж нөлөө болон эмийн аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн мэдээлэх журам”-д өөрчлөлт оруулах тухай (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 89 дүгээр тушаал)
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаал)
- “Эмнэл зүйн туршилт явуулах, судалгаа, шинжилгээний зорилгоор хүний цус, цусан бүтээгдэхүүн, биологийн шингэн, эд, эрхтэн авах, хэрэглэх журам” (Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/526 дугаар тушаал)
- Эм зүйн салбарын сайн засаглалын удирдамж батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/190 дүгээр тушаал)
- Эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүй байдлын программыг нэвтрүүлэх журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/19 дүгээр тушаал)
- Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын лиценз олгох журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/407 дүгээр тушаал)
- Эмнэлгийн эм зүйн албаны үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/180 дүгээр тушаал)
- Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам батлах (Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаал)
- Журам шинчлэн батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400 дугаар тушаал)
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам (Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/493 дугаар тушаал)
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх журам (Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/344 дүгээр тушаал)
- Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга аргачлал (Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/345 дугаар тушаал)
- Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх арга аргачлал (Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/464 дүгээр тушаал)
- Эмийн эмчилгээг зохицуулах хорооны ажиллах журам батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/414 дүгээр тушаал)
- Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам батлах


- тухай (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаал)
- Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар батлах тухай (Эрүүл мэндийн сайдын 2017 оны 505 дугаар тушаал)
 - Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага (Эрүүл мэндийн сайдын 2013 оны 145 дугаар тушаал)

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

- Эм үйлдвэрлэлийн зохистой дадал /GMP/-ын батламж олгох журам батлах тухай (ЭЭХХЗГ-ын даргын 2021 оны А/168 дугаар тушаал)

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ:

- Биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх байгууллагад тавих шаардлага MNS 6396:2013
- Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага. MNS 5530:2014
- Эмийн идэвхт бодис ба эмийн тогтвортой чанарын судалгаанд тавих ерөнхий шаардлага. MNS 6439:2014
- Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-1:2014
- Биобэлдмэлийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-2:2014
- Уламжлалт эмийн үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага. MNS 5524-3:2015
- Фармакопейн өгүүлэл боловсруулах арга зүй. MNS 5763:2015
- Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага. MNS 5260:2015
- Эмийн анхдагч савлалтын материалд тавих ерөнхий шаардлага. MNS 6622-2016
- Эмийн жорын маягт, жор бичилтийн стандарт MNS 5376:2016
- Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага. MNS 6621-2016
- Эмнэлгийн цахилгаан тоног, төхөөрөмж, 2-25-р хэсэг: Зүрхний цахилгаан бичлэгийн аппаратын үндсэн үзүүлэлт, аюулгүй ажиллагаанд тавих шаардлага MNS/IEC 60601-2-25:2019
- Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмж. Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмжийн ээлжит болон засварын дараах туршилт MNS/IEC 62353:2019
- Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага MNS/ISO 17025



2.2. ЭМ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ

Эм хангамжийн байгууллагын үзүүлэлтийг дараах чиглэлээр гаргав.

- Эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэр
- Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага
- Эмийн сан


2021 онд нийт 2714 эм хангамжийн байгууллага үйл ажиллагаа явуулснаас 82.74% нь эмийн сан, 15.74% нь ханган нийлүүлэх байгууллага, 1.52% нь үйлдвэр эзэлж байна. (Хүснэгт-1)

№	Эм хангамжийн байгууллагын төрөл	2017		2018		2019		2020		2021	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Нийт үйлдвэр	46	1.9%	41	1.6%	59	2.4%	38	1.4%	43	1.52%
2	ХНБ	384	16%	360	14.2%	357	14.7%	384	13.9%	336	15.74%
3	Эмийн сан	1967	82.1%	2128	84.1%	2015	82.9%	2343	84.7%	2335	82.74%
	Нийт	2397	100%	2529	100%	2431	100%	2765	100%	2714	100%


Хүснэгт 1. Эм хангамжийн байгууллагын тоо, төрлөөр (2017-2021)

2.2.1. ҮЙЛДВЭРЛЭЛ

Монгол Улсын хэмжээнд 2021 онд үйлдвэрлэлийн чиглэлээр 43, ханган нийлүүлэх чиглэлээр 444 байгууллага үйл ажиллагаа явуулсан байна. /Зураг-6,7/



Зураг 6. Үйлдвэрийн тоо (2017-2021)




Зураг 7. Үйлдвэрийн үйл ажиллагааны чиглэл (2021)

2021 онд эм үйлдвэрлэх чиглэлд 1, Биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох чиглэлд 2, Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх чиглэлд 2 байгууллагад тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. /Зураг-8,9/



БАЙГУУЛЛАГЫН НЭР	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ
Самал	БИБ үйлдвэрлэх, экспортлох
Нөхөд	БИБ үйлдвэрлэх, экспортлох
Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Цөмийн оношилгоо эмчилгээний төвийн “Циклотронд суурилсан цацраг идэвхт эмийн үйлдвэрлэл”	Эм үйлдвэрлэх
Гранд эко эхлэл	Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх
Мон тариур	Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх

Хүснэгт 2. Шинээр авсан үйл ажиллагааны чиглэл



Зураг 8. Нийт үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагын тоо (2017-2021)

2021 онд эмийн үйлдвэрүүд нийт 386 нэр төрлийн эм үйлдвэрлэснээс 191 нэрийн эм (49%), 18 нэрийн эмнэлгийн хэрэгсэл (5%), 22 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүн (6%), 132 нэрийн уламжлалт эм (34%), 23 нэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодис (6%) үйлдвэрлэсэн байна.




■ Эм ■ Эмнэлгийн хэрэгсэл ■ Биологийн идэвхт бүтээгдэхүүн
■ Уламжлалт эм ■ Ариутгалын бодис

Зураг 9. Үндэсний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний нэр төрлийн эзлэх хувь (2021)

2021 онд тусгай зөвшөөрөлтэй дотоодын 43 үйлдвэр нь эм, эмнэлгийн хэрэгсэл, протез, биологийн идэвхт бүтээгдэхүүн, ариутгал, халдваргүйтгэлийн бодис, мансууруулах сэтгэцэд нөлөөт эм, биобэлдмэл, цацраг идэвхт эм үйлдвэрлэх нийт давхардсан тоогоор 76 чиглэлээр үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна

2.2.2. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

2021 оны байдлаар нийт тусгай зөвшөөрөлтэй 444 ханган нийлүүлэх байгууллагууд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулсан байна /давхардсан тоогоор/. Үүнд: /Зураг-10/



Зураг 10. Ханган нийлүүлэх байгууллагын үйл ажиллагааны чиглэл (2021)


2.2.3. ЭМИЙН САН

Монгол улсын хэмжээнд 2021 оны байдлаар нийт 2335 эмийн сан үйл ажиллагаа явуулснаас 1-р зэрэглэлийн 217, 2-р зэрэглэлийн 1806 (77.34%), эргэлтийн 312 (13.36%) эмийн сан байна. (Хүснэгт-3,4)

Байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотод 1325 (56.75%), хөдөө орон нутагт 1010 (43.25%) эмийн сан үйл ажиллагаа явуулжээ. Үүнээс Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт эмийн сангаас 1-р зэрэглэлийн 76, 2-р зэрэглэлийн 1249 эмийн сан тус тус ажилласан байна. /Зураг-11/


№	Аймаг, хотын нэр	I зэрэглэлийн эмийн сангийн тоо					II зэрэглэлийн эмийн сангийн тоо					Эргэлтийн эмийн сан		Нийт
		2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021	Сумын	Хувийн	
1	Архангай	4	4	4	4	4	39	39	54	54	56	-	18	60
2	Баян-Өлгий	2	2	2	2	2	26	27	37	37	49	14	-	51
3	Баянхонгор	5	6	7	10	11	13	15	14	13	35	-	20	46
4	Булган	2	2	3	3	2	22	19	35	24	27	-	13	29
5	Говь-Алтай	4	1	-	1	2	10	14	31	12	33	-	19	35
6	Говьсүмбэр	1	-	-	-	-	8	10	10	7	10	-	-	10
7	Дархан-Уул	11	8	10	7	6	43	52	48	53	57	-	-	63
8	Дорноговь	11	11	11	10	10	10	16	17	15	37	17	-	47
9	Дорнод	8	9	8	11	11	12	24	18	22	44	13	-	55
10	Дундговь	3	3	4	5	5	15	6	7	7	22	15	-	27
11	Завхан	4	4	2	2	2	19	21	26	24	44	17	-	46
12	Орхон	37	36	39	48	50	20	21	19	18	27	-	-	77
13	Өвөрхангай	5	5	4	4	3	26	30	55	55	60	-	18	63
14	Өмнөговь	3	3	2	2	2	23	24	28	30	46	14	-	48
15	Сүхбаатар	3	3	3	4	4	12	13	12	10	23	12	-	27
16	Сэлэнгэ	7	9	9	9	7	35	35	47	26	46	20	-	53
17	Төв	1	1	-	-	-	26	29	29	29	59	26	-	59
18	Увс	5	9	7	6	6	18	13	20	21	46	18	-	52
19	Ховд	11	12	11	11	11	21	12	14	14	29	16	-	40
20	Хөвсгөл	2	2	2	2	2	23	46	45	49	71	-	23	73
21	Хэнтий	4	4	4	4	1	22	24	24	24	48	3	16	49
Орон нутгийн хэмжээнд		133	134	135	145	141	433	490	594	544	869	185	127	1010
Улаанбаатар		190	190	129	89	76	747	914	1075	1210	1249	-	-	1325
Улсын хэмжээнд		319	323	263	224	217	1114	1347	1565	1672	2118	207	104	2335

Хүснэгт 3. Эмийн сан, байршлаар (2017-2021)



№	Аймаг хотын нэр	I зэрэглэлийн хувийн эмийн сангийн тоо		II зэрэглэлийн хувийн эмийн сангийн тоо		Нийт
		2021	2021	2021	2021	
БАРУУН БҮС		23	117	84	224	
1	Баян-Өлгий	2	35	14	51	
2	Говь-Алтай	2	14	19	35	
3	Завхан	2	27	17	46	
4	Увс	6	28	18	52	
5	Ховд	11	13	16	40	
ХАНГАЙН БҮС		72	184	92	348	
1	Архангай	4	38	18	60	
2	Баянхонгор	11	15	20	46	
3	Булган	2	14	13	29	
4	Орхон	50	27	-	77	
5	Өвөрхангай	3	42	18	63	
6	Хөвсгөл	2	48	23	73	
ТӨВИЙН БҮС		30	185	92	307	
1	Говьсүмбэр	-	10	-	10	
2	Дархан-Уул	6	57	-	63	
3	Дорноговь	10	20	17	47	
4	Дундговь	5	7	15	27	
5	Өмнөговь	2	32	14	48	
6	Сэлэнгэ	7	26	20	53	
7	Төв	-	33	26	59	
ЗҮҮН БҮС		16	74	41	131	
1	Дорнод	11	31	13	55	
2	Сүхбаатар	4	11	12	27	
3	Хэнтий	1	32	16	49	
Орон нутгийн хэмжээнд		141	560	309	1010	
Улаанбаатар		176	1249	-	1325	
Улсын хэмжээнд		217	1809	309	2335	

Хүснэгт 4. Үйл ажиллагаа явуулсан эмийн сан, байршлаар (2021)



Зураг 11. Үйл ажиллагаа явуулсан эмийн сангийн тоо (2021)


2021 онд улсын хэмжээнд 134 эмийн санд тусгай зөвшөөрөл шинээр олгосон ба үүнээс Нийслэлийн эрүүл мэндийн газраас 49, Орон нутгийн засаг захиргаанаас 85 тусгай зөвшөөрөл тус тус шинээр олгосон байна.

2.3 ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2021 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 2913 эм зүйч, 2010 эм найруулагч ажиллаж байна. Өмнөх онтой харьцуулахад нийт эм зүйчийн тоо 0.8%-иар өссөн бол эм найруулагчийн тоо 13%-иар өссөн үзүүлэлттэй байна. (Хүснэгт-5)

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУД	ЭМ ЗҮЙЧ						ЭМ НАЙРУУЛАГЧ						
	2016	2017	2018	2019	2020	2021	2016	2017	2018	2019	2020	2021	
Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага													
Тосгоны эмнэлэг	1	1	1	5	1	0	11	12	11	18	5	0	
Сумын эрүүл мэндийн төв	14	19	26	35	43	47	166	134	141	265	148	141	
Сум дундын эмнэлэг	2	4	4	10	0	0	24	20	18	25	0	0	
Бүгд	17	24	31	50	44	47	201	166	170	308	153	141	
Дүүргийн нэгдсэн эмнэлэг	25	29	33	35	41	18	18	21	20	18	19	9	
Аймгийн нэгдсэн эмнэлэг	25	33	37	39	31	32	38	40	48	45	38	43	
Бүгд	50	62	70	74	72	50	56	61	68	63	57	52	
Бүсийн оношилгоо эмчилгээний төв	16	17	20	25	22	25	14	12	13	10	6	4	
Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төв	84	84	89	80	103	0	30	26	24	25	20	0	
Бүгд	100	101	109	105	125	25	44	38	37	35	26	4	
Амаржих газар	9	9	9	9	10	10	2	3	3	4	2	2	
Ортой хувийн эмнэлэг	54	58	10	25	75	89	34	33	12	12	27	35	
Үүдэн хувийн эмнэлэг (клиник)	18	14	10	10	22	22	4	6	10	10	10	6	
Эрүүл мэндийн яам, агентлаг	14	13	14	14	0	0	0	0	0	0	0	0	
Эрдэм шинжилгээний байгууллага	0	0	5	5	0	0	0	0	0	0	0	0	
Эрүүл мэндийн газар	18	16	2	1	11	8	4	3	0	0	4	7	
Яаралтай тусламжийн төв, дүүргүүд дэх салбар	1	1	1	27	1	1	9	9	10	10	11	11	
Сувилал	2	3	2	5	2	1	1	1	1	5	2	3	
Эм ханган нийлүүлэх байгууллага	81	107	107	251	117	135	92	109	115	103	137	117	
Эмийн үйлдвэр	93	108	100	123	0	0	25	21	46	46	0	0	
Эмийн сан /хувийн/	1124	1473	1699	1702	2112	2332	1224	1521	1538	1700	1556	1577	
Бүгд (Эрүүл мэндийн салбарт)	1414	1802	1959	2172	2597	2871	1395	1706	1735	1890	1992	1994	
АУ-ны сургууль, коллеж /улсын/	27	29	40	45	15	11	1	1	1	1	3	6	
АУ-ны сургууль, коллеж /хувийн/	34	38	35	38	0	0	0	1	0	0	0	0	
Бусад эмнэлэг (Хилийн цэрэг, хорихын эмнэлэг, Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг, Төмөр замын төв эмнэлэг)	19	18	20	25	27	25	12	13	11	11	14	8	
Бүгд (Бусад салбарт)	80	85	95	108	42	42	13	15	12	12	17	16	
Нийт	1581	1989	2169	2509	2639	2949	1696	1971	2010	2308	2009	2024	

Хүснэгт 5. 2021 онд орон нутагт эрүүл мэндийн салбарт ажилласан эм зүйч, эм найруулагчийн тоо, байршлаар




Улсын ба хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллежид эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсгөгч бэлтгэн гаргаж байна. 2021 онд нийт 676 эм зүйч, 67 эм найруулагч мэргэжлээр төгссөн байна.

2020 онтой харьцуулахад эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн тоо 32%-иар өссөн, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо 35%-иар буурсан үзүүлэлттэй байна. (Хүснэгт-6)

№	Аймаг	ЭМ ЗҮЙЧ		ЭМ НАЙРУУЛАГЧ	
		2020	2021	2020	2021
УЛСЫН ДУНДАЖ			2949		2024
БАРУУН БҮС					
1	Баян-Өлгий	48	57	65	57
2	Говь-Алтай	34	5	55	53
3	Завхан	28	32	46	44
4	Увс	53	57	39	43
5	Ховд	54	38	56	45
ХАНГАЙН БҮС					
1	Архангай	36	26	64	50
2	Баянхонгор	47	53	55	61
3	Булган	25	8	39	22
4	Орхон	101	97	140	87
5	Өвөрхангай	36	57	50	54
6	Хөвсгөл	43	40	81	66
ТӨВИЙН БҮС					
1	Говьсүмбэр	12	9	10	14
2	Дархан-Уул	61	74	92	109
3	Дорноговь	41	38	77	64
4	Дундговь	22	27	25	23
5	Өмнөговь	48	42	49	33
6	Сэлэнгэ	26	26	83	82
7	Төв	17	30	31	50
ЗҮҮН БҮС					
1	Дорнод	33	37	45	45
2	Сүхбаатар	22	18	32	36
3	Хэнтий	21	31	68	46
УЛААНБААТАР		1831	1660	807	723
НИЙТ		2639	2949	2009	2024


Хүснэгт 6. Эм зүйч, эм найруулагч мэргэжлээр төгсөгчдийн тоо

2021 онд АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийг 81, ЭЗШУИС-ийг 249, Этүгэн их сургуулийг 158, ШАУИС-ийг 70 төгсөгч эм зүйч мэргэжлээр төгссөн байна. /Зураг 12/



Зураг 12. Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн тоо (2021)

2021 онд АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийг 47, Говь-Алтайн АУК-ийг 29, Дарханы АУК-ийг 27, Дорноговийн АУК-ийг 7 төгсөгч эм найруулагч мэргэжлээр төгссөн байна. /Зураг-13/





Зураг 13. Эм зүйч мэргэжлээр төгсөгчдийн тоо (2021)

2.4. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


2.4.1. ЭМИЙН САНХҮҮЖИЛТ

Эрүүл мэндийн салбарын төсөв 2021 онд 1.69 их наяд төгрөг болсон нь өмнөх онтой харьцуулахад 444.6 тэрбум төгрөгөөр буюу 35.7%-иар өссөн. Үүнээс эм, эмнэлгийн хэрэгслийн төсөв 542.4 тэрбум төгрөг болсон бөгөөд 2020 онтой харьцуулахад 354.1 тэрбум төгрөгөөр буюу 188%-иар өссөн байна. /Зураг-14/




Зураг 14. Эрүүл мэндийн төсөв, тэрбум төгрөгөөр (2015-2021)

2021 оны байдлаар 510 нэрийн эмэнд 60.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан эмийн сангуудад олгосон байна. /Зураг-15/



Зураг 15. ЭМД-ын сангаас олгосон эмийн үнийн хөнгөлөлт /тэрбум төгрөг/

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад багтсан 141 ерөнхий нэршлийн 574 худалдааны нэрийн эм эрүүл мэндийн даатгалын сангаас 30-70 хувийн үнийн хөнгөлөлт олгож, гэрээ бүхий эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилт олгосон байна. Хамгийн их хөнгөлөлт олгосон 10 нэрийн эмийг жагсаалтаар гаргав. /Зураг-16/




Зураг 16. ЭМД-аас хамгийн их хөнгөлөлттэй олгосон 10 нэрийн эм, ширхэгээр (2021)


2.4.2. ЭМИЙН ИМПОРТ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА

2.4.2.1 ЭМИЙН ИМПОРТ


2021 онд эмийн 489.7 тэрбум төгрөгийн импорт, 431 тэрбум төгрөгийн борлуулалт (бөөний үнээр) хийсэн нь 2020 онтой харьцуулахад импорт 96.2 тэрбум төгрөг буюу 19.6%-иар, борлуулалт 62.1 тэрбум төгрөг буюу 9.5%-иар тус тус өссөн байна. /Зураг-17/



Зураг 17. Эмийн импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр (2015-2021)




2021 онд 121.4 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгслийн импорт, 107.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2020 онтой харьцуулахад импорт 4.4 тэрбум төгрөгөөр, борлуулалт 2.2 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. /Зураг-18/




Зураг 18. Эмнэлгийн хэрэгслийн импорт, борлуулалт /тэрбум төгрөг/ (2015-2021)

2021 онд нийт 43 тэрбум төгрөгийн урвалж, стандарт бодис импортлож, 38 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2020 онтой харьцуулахад импорт нь 29.7 тэрбум төгрөг, борлуулалт 26.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. /Зураг 19/



Зураг 19. Урвалж, стандарт бодисын импорт, борлуулалт, тэрбум төгрөгөөр (2015-2021)

2021 онд нийт 68.3 тэрбум төгрөгийн оношлуур импортолж, 59.7 тэрбум төгрөг борлуулалт хийсэн нь 2020 онтой харьцуулахад импорт 43,7 тэрбум төгрөг, борлуулалт 36,5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг-20/





Зураг 20. Оношлуурын импорт, борлуулалт ,тэрбум төгрөг (2015-2021)

2.4.2.2. ЭМИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ


2021 онд Монгол улсын хэмжээнд 25 үндэсний үйлдвэр ажиллаж нийт 105.9 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эм, ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 97.8 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Үүнээс: 59.7 тэрбум төгрөгийн европ эм үйлдвэрлэж, 60 тэрбум төгрөгийн борлуулалт, 28.2 тэрбум төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэж, 22.3 тэрбум төгрөгийн борлуулалт, 6.8 тэрбум төгрөгийн биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 5 тэрбум төгрөгийн борлуулалт, 5.6 тэрбум төгрөгийн уламжлалт эм үйлдвэрлэж, 4.6 тэрбум төгрөгийн борлуулалт, 5.72 тэрбум төгрөгийн ариутгал халдваргүйтгэлийн бодис үйлдвэрлэж, 5.73 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад үндэсний үйлдвэрийн ариутгал халдваргүйтгэлийн бодисын үйлдвэрлэл буурч, эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл өссөн байна. Нийт дүнгээр авч үзвэл өнгөрсөн оноос 2021 онд үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүн үнийн дүнгээр 67%-иар өссөн байна. /Зураг-21,22/



Зураг 21. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тэрбум төгрөгөөр (2017-2021)




■ Эм ■ Эмнэлгийн хэрэгсэл ■ Биологийн идэвхит бүтээгдэхүүн ■ Уламжлалт эм ■ Ариутгалын бодис

Зураг 22. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүний эзлэх хувь 2021 он


2.4.3. ЭМ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, ТҮГЭЭЛТ

Эрүүл мэндийн салбарт 2021 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль”-ийн дагуу 435.7 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хийсэн байна. /Зураг-23/




Зураг 23. Эм, эмнэлгийн хэрэгслийн төсөвт өртөг ба худалдан авах ажиллагааны гэрээний дүн, /тэрбум төгрөг/ (2015-2021)

Үүнээс эм 81.7 тэрбум (18.8%), эмнэлгийн хэрэгсэл 46.9 тэрбум (10.8%), урвалж оношлуур 42.6 тэрбум (9.8%), ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис 2.6 тэрбум (0.6%), вакцин (КОВИД-19) 247.7 тэрбум (67.4%), бусад вакцин 13.9 тэрбум (3.2%) төгрөгийн худалдан авалт хийсэн байна. /Зураг-24/



Зураг 24. Худалдан авсан нэр төрлийн эзлэх хувь, 2021 он




2.5. ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.5.1. ЭМИЙН БҮРТГЭЛ

Хүн ам, эрүүл мэндийн байгууллагыг чанартай, аюулгүй, эмчилгээний идэвхтэй эмээр хангах зорилгоор эмийн бүртгэлийн үйл ажиллагааг Монгол улсад 1994 оноос хэрэгжүүлж эхэлсэн.


Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйлд үндэслэн Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалын дагуу эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна.

/Зураг-25/




Зураг 25. Монгол Улсын эмийн бүртгэлд шинээр бүртгэгдсэн эм (1994-2021)

2021 онд нийт 290 эм бүртгэгдсэн. Үүнээс импортын эм 241, үндэсний үйлдвэрийн эм 38, импортын уламжлалт эм 11 бүртгэгдсэн байна. Мөн эмийн түүхий эд 23, биологийн идэвхт бүтээгдэхүүн 212 тус тус бүртгэгдсэн. /Зураг-26/




Зураг 26. Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн эм, эмийн түүхий эдийн тоо (2016-2021)

2021 оны байдлаар Монгол Улсад нийт бүртгэлтэй 4175 эм байна. Үүнээс 28.68% нь жоргүй олгох, 70.23% нь жороор олгох, 1.02% нь эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эм байна. /Зураг 27/




Зураг 27. Бүртгэлтэй эмийн олгох нөхцөл /хувиар/ (2021)


2021 онд Монгол Улсын эмийн бүртгэлд хамгийн их бүртгэгдсэн эхний 10 улсыг авч үзвэл /Зураг 28/



Зураг 28. Монгол Улсын эмийн бүртгэлд хамгийн их бүртгэгдсэн эхний 10 улс, хувиар (2021)




2021 онд бүртгэгдсэн нийт эмийн 10.6%-ийг Үндэсний үйлдвэрийн эм эзэлж байна. /Зураг-29/




Зураг 29. Эмийн бүртгэлд үндэсний үйлдвэрийн эмийн эзлэх хувь (2016-2021)

2021 онд Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн нийт эмийг АТС ангиллаар авч үзвэл: /Зураг 30/




Зураг 30. АТС ангилал эзлэх хувиар /2021/

Монгол улсад 2017-2021 онуудад бүртгэгдсэн Үндэсний үйлдвэрийн эм, Уламжлалт эм, Импортын эм, Биологийн идэвхт бүтээгдэхүүн, оношлуурын тоон мэдээллийг харуулав. /Зураг 31/




Зураг 31. Монгол Улсад бүртгэгдсэн эм, БИБ, оношлуур (2017-2021)

Монгол улсад 2016-2021 онуудад бүртгэгдсэн Оношлуурын тоон мэдээллийг харуулав. /Зураг 32/




Зураг 32. Монгол улсад бүртгэгдсэн оношлуур (2016-2021)



2.5.2. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Мэргэжлийн хяналтын байгууллагаас Эм хангамжийн байгууллагуудад “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэдэг.


Хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан эм хангамжийн байгууллагын тоог 2015-2021 оноор авч үзвэл: /Зураг-33/



Зураг 33. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын тоо (2016-2021)

Төлөвлөгөөт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд 2021 онд 278 эм хангамжийн байгууллага хамрагдсан байна.

Нийт хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан байгууллагад эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн эзлэх хувийг харуулав. /Зураг 34/




Зураг 34. Хяналт шалгалтад хамрагдсан эм хангамжийн байгууллагын хувь (2015-2021)


Хяналт шалгалтаар илэрсэн улсын бүртгэлд бүртгэгдээгүй, хүчинтэй хугацаа дууссан, хаяг шошгын зөрчилтэй, хадгалалтын дэглэм алдагдсан, лабораторийн шинжилгээнд хамрагдсан бүтээгдэхүүний тоог хүснэгт 8-д харуулав. /Зураг-35/

№	ЧАНАРЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ									
	Монголд бүртгэгдээгүй		Хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан		Хаяг шошгын зөрчилтэй		Хадгалалтын дэглэм алдагдсан		Лабораторит шинжлүүлсэн дээж	
	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэр төрөл	Тоо ширхэг	Нийт	Хангаагүй
2014	41	479	130	2025	59	539	58	520		
2015	129	2291	223	5275	134	6481	13	190		
2016	131	2703	420	3060	-	-	59	1370		
2017	138	13310	350	11606	32	6809	49	1205	82	15
2018	169	44168	35	678	-	-	1	1109	73	8
2019	316	16906	308	9272	11	122	14	180	89	17
2020	178	12379	328	23927	65	3479	3	120	20	3
2021	109	9287	592	19862	7	3658	61	15032	126	4
Нийт	1211	101523	2386	75705	308	21088	258	19726	390	47

Хүснэгт 7. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй бүтээгдэхүүний тоо



Зураг 35. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилтэй бүтээгдэхүүний ангилал (2014-2021)




2.5.3. ЭМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Эмийн гаж нөлөөний идэвхгүй тандалтыг тохиолдол мэдээлэх eReporting цахим систем ба гаж нөлөөний тохиолдол мэдээлэх хуудсаар дамжуулан иргэд, эрүүл мэндийн байгууллагаас хүлээн авч, дүн шинжилгээ хийн ажиллаж байна. 2022 оны 07 дугаар сарын байдлаар мэдээлсэн гаж нөлөөний 44 тохиолдлын шалтгаан хамаарал, эрсдэлийн үнэлгээг Эм судлалын салбар зөвлөлийн 4 удаагийн хурлаар хэлэлцүүлсэн.

2022 оны эхний улирлаас эхлэн гадаадын эм үйлдвэрлэгч нараас [/gajnoloo@mmra.gov.mn/](mailto:gajnoloo@mmra.gov.mn) и-мэйл хаягаар давхардсан тоогоор 168, нэр төрлөөр 20 эмийн гаж нөлөөний тохиолдлын мэдээллийг (CIOMS- Council for International Organizations of Medical Sciences) шууд хүлээн авсан.

2022 оны эхний улирлын байдлаар 100 эмийн аюулгүй байдлын хугацаат тайланг (PSUR) хүлээн авсан ба аюулгүй байдлын мэдээлэлд орсон өөрчлөлт байхгүй байна. /Зураг-36/



Зураг 36. Эмийн гаж нөлөө аюулгүй байдлын тоо (2017-2022)

2.5.4 ЭМИЙН СОНГОЛТ

